



МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН  
MILLENNIUM CHALLENGE ACCOUNT - MONGOLIA

## УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ХУРААНГУЙ

Огноо: 2019 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр  
Хурал болсон газар: Гадаад харилцааны яам

### ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

Монголын Мянганы сорилтын сан /Монголын МСС/-ийн Удирдах зөвлөлийн ээлжит хурлаар дор дурдсан 8 асуудлыг хэлэлцэж, харгалзах шийдвэрийг батлав. Үүнд:

1. Монголын МСС-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн ээлжит бус хурлын тэмдэглэлтэй гишүүд танилцаж, санал нэгтгэйгээр батлав.
2. Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн хөрөнгөөр 2019.010.01-нээс 2020.09.30-ны хооронд хэрэгжүүлэх Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг гишүүд хэлэлцэж, Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг санал нэгтгэйгээр батлав.
3. Монголын МСС-ийн 2019 оны 4 дүгээр улирлын Санхүүжилтийн төлөвлөгөөний төслийг гишүүд хэлэлцсэний үндсэн дээр санал нэгтгэйгээр баталж, МСК-д уламжлахаар шийдвэрлэв.
4. Монголын МСС-д худалдан авах ажиллагааны болон санхүүгийн үйлчилгээ үзүүлэх зөвлөх компанитай байгуулсан гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг тус тус хэлэлцэж, санал нэгтгэйгээр батлав.
5. Монголын МСС-ийн мэдээлэл технологийн дэд бүтцийг суурилуулж, удирдлагын мэдээллийн системийн програм хангамжийг нийлүүлэх Iron Vine Security компанитай байгуулсан гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцээд, Vine Security компанитай байгуулсан гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг санал нэгтгэйгээр батлав.
6. Монголын МСС-ийн Дотоод аудитын дүрмийн төслийг хэлэлцэж, гишүүдээс өгсөн санал, зөвлөмжийг дүрмийн төсөлд тусгах нөхцөлтэйгөөр Монголын МСС-ийн Дотоод аудитын дүрмийн төслийг санал нэгтгэйгээр батлав. Түүнчлэн Монголын МСС-ийн Дотоод Аудитын захирлын танилцуулснаар Удирдах зөвлөлийн дэргэд Аудитын хороо байгуулах тухай саналыг Удирдах зөвлөлийн дарга, гишүүд дэмжиж, Аудитын Хорооны дүрмийн төсөл боловсруулахыг даалгав.
7. Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн хүрээнд Ус сувгийн удирдах газрын зардлыг нөхөх төлөвлөгөө боловсруулах чиглэлээр хийгдэж буй техникийн

туслалцааны талаар Монголын МСС-ийн Жендэр, нийгмийн оролцооны захирал танилцуулав.

8. Удирдах зөвлөлийн зарим гишүүд Компакт гэрээ хүчин төгөлдөр болоход шаардагдах урьдчилсан болзолт нөхцлүүдийг хангах чиглэлээр хийгдэж байгаа ажлын явцын талаар мэдээлэл хийв.

МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН